



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/350

Бсөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэг, 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 30.2.1 дэх заалт, Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 55 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Япон улсын "Өвсний үндэс" хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААХААГ/20240101109 дугаартай "Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн барилгын ажлыг "Хүслэнт хүдэр" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

